



КОВИД-19 БА ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

УДИРТГАЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Монголын аутизмын холбоо хамтран КОВИД-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй айл өрхөд хэрхэн тусаж байгаа талаарх судалгааг хийлээ. Өмнөх судалгаа нь 2020 оны 4 дүгээр сарын нөхцөл

байдлыг хамарсан бол энэ удаагийн хоёр дахь судалгаа нь 5 сарын нөхцөл байдлыг судлан үр дүнг Та бүхэнд хүргэж байна. Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр иргэний нийгмийн байгууллагуудын хэрэгжүүлж байгаа цуврал судалгааны энэ удаагийн асуулгад хот, хөдөөгийн 100 гаруй өрх оролцлоо.

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Засгийн Газрын 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн шийдвэрийн дагуу БСШУС-ын Сайдын 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн тушаалаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль (ЕБС), коллеж, их, дээд сургуулийн сургалтыг теле болон цахим хэлбэрт шилжүүлэн хэрэгжүүлж байгаа билээ.

Улсын Их Хурал (УИХ) 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хууль баталж, улмаар иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах; эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх; ажлын байрыг хадгалах, үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд тусламж үзүүлэх; бүх шатны сургалтын байгууллага цахим, эсхүл бусад хэлбэрээр зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх, багш болон суралцагчийн оролцоо, түүнд тавих хяналтыг сайжруулах зэрэг арга хэмжээг шуурхай төлөвлөн, хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн Газарт үүрэг болгосон юм.

Улмаар төрөөс хэрэгжүүлж буй бэлэн мөнгөний дэмжлэг үзүүлэх хэд хэдэн хөтөлбөрийг 2020 оны

10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл түр хугацаагаар тэлэх шийдвэрийг Засгийн Газраас 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдөр гаргасан бөгөөд үүнд:

- 18 хүртэлх насны хүүхэд бүрд олгож буй сарын 30,000 төгрөгийн тэтгэмжийг 70,000 төгрөгөөр нэмэгдүүлж 100,000 төгрөг болгох;
- хүнсний дэмжлэг шаардлагатай нэн ядуу өрхийн насанд хүрсэн гишүүнд 16,000 төгрөг, хүүхдэд 8,000 төгрөгийн хүнс худалдаж авах эрхийн бичиг олгож буйг хоёр дахин нэмэгдүүлэн, насанд хүрсэн хүнд 32,000, хүүхдэд 16,000 төгрөгийн хүнсний эрхийн бичиг олгох;
- нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 100,000 төгрөгөөр нэмэгдүүлэх (үүнд халамжийн тэтгэвэр авдаг хөгжлийн бэрхшээлтэй 42,000 хүн багтаж байна) зэрэг арга хэмжээ багтжээ.

Мөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд асрдаг хүний байнгын асаргааны тэтгэмжийг 2020 оны 2 дугаар сараас нэмэх (асаргааны тэтгэмж сард 123,100 төгрөг, бусад асаргааны тэтгэмж сард 84,500 төгрөг болж нэмэгдсэн) шийдвэрийг өмнө нь гаргаад байсан билээ.

Уг судалгаанд КОВИД-19-ийн тархалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй нийгэм, эдийн засгийн бодлого, мөн орлого дэмжих зорилготой дээрх дөрвөн арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхийн амьдрал, амьжиргаанд хэрхэн нөлөөлж буйг 2020 оны 5 дугаар сарын байдлаар

баримтжуулахыг зорив. Мөн тэгш хамруулан сургах боловсролын бодлого албан ёсоор улс орон даяар хэрэгжиж эхэлсэн эхний жилд хичээл сургалт зайны болон цахим хэлбэрт шилжсэн явдал нь хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад хэрхэн нөлөөлж байгаа талаар эцэг эхийн үнэлгээг сонсохыг зорив.

1. ЦАР ТАХЛААС СЭРГИЙЛЭХ ҮЕИЙН ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

ӨРХИЙН ОРЛОГО

Өмнөх сарын судалгаатай харьцуулахад өрхийн орлого, зардалтай холбоотой асуултад оролцох идэвх нэмэгдэн, нийт оролцогчдын 84.2 хувь нь энэ хэсэгт хариулжээ.

Судалгааны энэ хэсэгт хариулт өгсөн 101 оролцогчоос 95 нь хүүхдийн мөнгө 70,000, нийгмийн халамжийн тэтгэвэр 100,000 төгрөгөөр тус тус нэмэгдсэнийг онцгойлон дурджээ. 95 өрхөөс 92 нь нэмэгдсэн 4 төрлийн мөнгөн дэмжлэгийн аль нэгийг, эсвэл давхар авсан байна. Нэмэгдсэн мөнгөн дэмжлэгийг аваагүй 3 өрх нь халамж асаргааны мөнгө авдаггүй, хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргаж байгаагүй хүмүүс байна. Тиймээс хүүхдийн мөнгө, хүнсний эрхийн бичиг, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг авах ёстой оролцогчид бүгд авчээ.

Халамжийн мөнгө нэмэгдсэн нь өрхийн амьжиргааг тогтвортой байлгахад тус болж байна гэж 21 оролцогч дүгнэсэн байна. Нэг өрх ажилгүй болсны улмаас 500,000 төгрөгийн орлогоо алдаад байсан ч хүүхдийн мөнгө нэмэгдэж 300,000 төгрөгийн төлөвлөөгүй орлого орж ирсэн нь хямралаас хамгаалж чаджээ.

ХЭНИЙ ОРЛОГО БУУРСАН БЭ?

Судалгааны дүнгээс харахад, 40 өрхийн орлого буурсан бол үүнээс 11 өрхийн амьжиргаа муудах хэмжээний нөлөөлөл үүсжээ.

Хил хаагдсаны улмаас БНХАУ-ын Эрээн хотод очиж ажиллах боломжгүй, жуулчны бааз хаагдсаны улмаас ажлаас халагдсан, жижиг уурхай зогссоны улмаас ажилгүй болсон 12 хүн байна. Жижиг, дунд бизнесийн бараа бүтээгдэхүүний борлуулалт муудсаны улмаас 4 өрхийн орлого буурчээ. Өөр 4 өрхийн санхүү хямарч, амьдрал хүнд байдалд орсон гэсэн ерөнхий тайлбар өгсөн байна. Өмнөх 4 дүгээр сарын судалгааны дүнтэй адилаар, байнгын ажлын байргүй, цагаар эсвэл улирлын шинжтэй хөдөлмөр эрхэлж байсан хүмүүст түр болон цагийн ажил олдохоо больж, орлогогүй буюу орлого буурсан, тогтмол бус болжээ. Дашрамд дурдахад, оролцогч 100 гаруй өрхийн гишүүдээс ажлын байраа хадгалж байгаа ААН-ийн ажилтанд сар бүр олгох 200,000 төгрөгийн дэмжлэгийн авсан хүн алга байв. Тэрчлэн, хүүхдээ харах гэж нэг оролцогч ажлаасаа гарчээ.

Орлого, зарлагын тэнцлийг хадгалахын тулд өрхүүд худалдан авах бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хязгаарлах, бусдаас зээлэх (2 оролцогч) зэргээр амьжиргаагаа залгуулж байна.

ӨРХИЙН ЗАРДАЛ

Судалгаанд оролцогчдын 97 хувь нь энэ сарын орлогоо өрхийн хоол хүнс, мах, өргөн хэрэглээний бараа зэрэг өдөр тутмын хэрэглээнд, зээл, байрны түрээс зэрэг зайлшгүй төлбөрт, мөн хүүхдийн

хэрэгцээт эм тариа, живх, хувцас зэрэгт зарцуулжээ. 3 өрх нь хүүхдийн мөнгөөр хадгаламж үүсгэн хуримтлуулж байгаа ба үүнээс нэг өрх нь хүүхдийн мөнгийг хуримтлуулж байгаад хожим хүүхдийнхээ

эмчилгээнд хэрэглэхээр төлөвлөжээ. Судалгаанд оролцогч 15 өрхийн зардал өссөн бол банкны зээлээ төлж чадахгүй өрийн дарамтад ороод байгаа 2 оролцогч байна.

ЯМАР ЗАРДАЛ НЭМЭГДСЭН БЭ?

Нэмэгдсэн мөнгөн тэтгэмжүүдийн ачаар орлого өссөн, эсвэл орлого хэвийн байгаа ч зардал нэмэгдсэн гэж 4 оролцогч онцолсон бол 16 оролцогч махны үнэ болон хэрэглээ нэмэгдсэн, хүүхэд харах хүн хөлслөх шинэ хэрэгцээ үүссэн, эмнэлгийн тусламж үйлчилгээний зардал нэмэгдсэн зэргээс болж өрхийн зардал өссөн гэжээ. 10 оролцогч махны үнэ өсөхтэй зэрэгцээд сургууль, цэцэрлэгт явахгүй байгаа хүүхэд, ажилгүй болсон юмуу гэрээсээ ажиллаж буй насанд хүрэгчдийн хүнс, ялангуяа махны хэрэглээ мэдэгдэхүйц өссөн гэж тайлбарлажээ. Ердийн хэрэглээнээс гадна хүүхдийнхээ бухимдлыг тайлах, дархлааг дэмжих гэж амттан, шинэ хувцас, аминдэм,

уураг авч байгаа гэж оролцогчид онцолжээ.


Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тогтмол хэрэглэдэг зарим нэр төрлийн эм, тариа, асаргааны зарим хэрэгсэл ховордсоны улмаас үнэ нэмэгдсэн нь ноцтой асуудал юм.

Өмнөх судалгаатай харьцуулахад өрхүүдийн өдөр тутмын хоол хүнс (ялангуяа мах), мөн нийгэмшихгүй байгаа хүүхдийг тайвшруулахаар чихэр жимс, түүний эрүүл мэндийг дэмжих витамин, уураг авч байгаа нь өрхийн зардлыг өсгөж байгаа гэсэн ажиглалт 5 дугаар сарын судалгаанд мөн давтагдлаа. Харин 4 дүгээр сард өрхүүдийн түлш, цахилгаан, интернэтийн зардал өссөн бол 5 дугаар сард энэ зардал дурдагдаагүй нь өмнөх сараас өсөөгүй, мөн дулаан болсон тул хүүхдээ хөдөө явуулах, хашаанд тоглуулах, агаар салхинд авч гарах зэргээр гэртээ сууж интернэт тогтмол ашиглах нь багассантай холбоотой байх магадлалтай.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ОРЛОГОГҮЙ БОЛОХ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ, ОРЛОГО ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНД БАГТАЖ ЧАДАХГҮЙ ӨРХИЙГ ХЭРХЭН ХАМГААЛАХ ВЭ?

ХАЛАМЖ НЭМЭГДСЭН НЬ ӨРХИЙН АМЬЖИРГААНД ЭЭРЭГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЖ БАЙНА УУ?



КОВИД-19-ийн цар тахлын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор халамжийн тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнсний дэмжлэгийг түр хугацаанд нэмэгдүүлэх Монгол Улсын Засгийн Газрын шийдвэр нь судалгаанд оролцсон 5 өрх тутмын 1-д эергээр нөлөөлжээ. Халамжийн мөнгө нэмэгдсэн нь өрхийн амьжиргаанд эерэг нөлөө үзүүлсэн гэж

21 оролцогч дүгнэсэн бол халамж нэмэгдсэн ч зардлын өсөлтийг гүйцэхгүй байна гэж 40 хүн, үүнээс 11 нь халамж нэмэгдсэн ч амьжиргаа муудсан гэж дүгнэжээ. Цаашдын нөхцөл байдал тодорхойгүй тул оролцогчдын ирээдүйд итгэх итгэл суларч, өрхийнхөө орлого, зарлагын байдлыг "одоохондоо гайгүй" гэж үнэлэх нь 5 дугаар сард нэмэгджээ.

Өрхүүд орлогоо хоол хүнс зэрэг өдөр тутмын хэрэглээ; зээл, түрээс зэрэг зайлшгүй зардал, хүүхдийн эм тариа, асрамжийн хэрэгсэл, амин дэм, уураг, мөн хүүхдээ тайвшруулах, дэмжих зорилгоор чихэр амттан, амин дэмд зарцуулж байгаа ажээ. Махны үнэ болон хэрэглээ нэмэгдэн, хөгжлийн бэрхшээлтэй зарим хүүхдийн тогтмол хэрэглэдэг эм, тариа, асаргааны эд зүйл ховордсоноос үнэ нь өсжээ.

Хөл хорио тогтоож, хилээ хаасан үед хөдөлмөрийн гэрээгээр хамгаалагдаагүй цагийн болон түр ажил хийдэг, гэрээрээ үйлдвэр, үйлчилгээ эрхэлдэг хүмүүсийн орлого хумигдаж байгаа бөгөөд албан ёсны хөдөлмөрийн салбарт жижиг, дунд үйлдвэрийн борлуулалт муудаж, жуулчны бааз болон жижиг уурхай зогссон зэрэг шалтгаан нь өрхүүдийн орлогод сөргөөр нөлөөлжээ.

КОВИД-19-ийн дэгдэлтийг урьдчилан сэргийлэх, дотооддоо алдахгүй байх чухал зорилтыг хэрэгжүүлэх явцдаа өрхийн амьжиргаа нь муудах эрсдэлтэй өрхүүдэд зорилтот арга хэмжээ шаардлагатай байна. Үүнд:

Хүнсний дэмжлэгийг түр хугацаагаар өргөжүүлэх боломжийг судлах. Үндэсний хэмжээнд тогтоосон ядуурлын шугамаас доогуур орлоготой өрхүүдэд төрөөс хүнсний дэмжлэг үзүүлдэг. Өнөөдрийн байдлаар уг хөтөлбөрт 44,325 өрхийн 240,500 хүн хамрагдаж байгаа нь манай нийт хүн амын 5 хувь юм¹. Уг бүлэгт багтаж байгаа насанд хүрэгч 32,000 төгрөг, хүүхэд 16,000 төгрөгийн хүнсний эрхийн бичгээр сар бүр сүү, ногоо зэрэг өргөн хэрэглээний 10 төрлийн хүнсний бүтээгдэхүүн худалдаж авах боломжтой. COVID-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 1 дүгээр сарын сүүлээс хил хааж, 3 дугаар сараас хэсэгчилсэн хөл хорио тогтоосон нь цагийн болон түр ажил хийдэг, гэрээрээ үйлдвэр үйлчилгээ эрхэлдэг, мөн жижиг дунд үйлдвэр, жуулчны салбар, жижиг уурхайд ажилладаг хүмүүсийн орлогыг эрс

хязгаарлажээ. Энэ нөхцөлд ядуурлын түвшний өргөн хэмжээний судалгаа хийх боломжгүй, мөн ядуурлын түвшнийг тооцоолох аргачлал өөр зэрэг байдлыг харгалзан орлогоо алдсан, ядууралд өртөх эрсдэлтэй өрхүүдийг түр хугацаагаар хүнсний эрхийн бичгийн хөтөлбөрт хамруулах боломжийг судлах хэрэгтэй гэж үзэж байна.

Ажлын байраа хадгалж байгаа аж ахуйн нэгжийн ажилтанд сар бүр олгохоор төлөвлөсөн 200,000 төгрөгийн дэмжлэгийн олголтод мониторинг хийж, ялангуяа жижиг, дунд үйлдвэрийнхэнд энэхүү дэмжлэг хэр хүрч байгааг тодруулах хэрэгтэй.

Зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд хяналт тавих. Хөгжлийн бэрхшээлийн төрөл, хэлбэрээс хамааран хөгжлийн бэрхшээлтэй зарим хүүхэд тодорхой эм, тариаг тасалдуулахгүй хэрэглэх, мөн асаргааны хэрэгсэл байнга ашиглах хэрэгцээтэй байдаг. Хил хаасны улмаас өргөн хэрэглээнд байдаггүй зарим эм, тариа тасарч, асаргааны зарим хэрэгсэл ховордохын хэрээр үнэ нь өссөөр байна. Эдгээр зүйлсийн хэрэглэгчийн тоо цөөн тул ховордох, үнэ өсөх нь харьцангуй цөөхөн хүн, өрхийн эрх ашгийг хөнддөг. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчийн өдөр тутмын, зайлшгүй хэрэглээ болсон эдгээр зүйл нь эм, эмийн хэрэгслийн бүртгэлд байдаг тул төрөөс хяналт тавьж, үнийг нь өсгөхгүй байхад анхаарах шаардлагатай байна.

Ойрын ирээдүйд итгэлтэй байх үүднээс дараагийн шатанд төрөөс хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлого, дэмжлэгийн талаар мэдээлэх. COVID-19-ийн цар тахлын эрсдэл буурахгүй, хөл хорио үргэлжлэх юм бол, мөн ийм хэрэгцээ үүсэхгүй ч эдийн засаг сэргэх хүртэлх хугацаанд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй дэмжлэгийн бодлогын талаар мэдээлэл өгөх нь иргэдэд амьдралаа төлөвлөх боломж олгон, сэтгэл санааны дэмжлэг болох юм.

¹ https://www.adb.org/news/adb-project-expands-food-stamps-and-cash-grants-poor-and-vulnerable-mongolia-wake-covid-19?fbclid=IwAR0BwA_hvcT0Lo8N4j5pw_ficp3fV2--eZ-1eRebn1QoNsPdLZlukyLxlbQ

2. ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ҮЕЭРХ НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Халамжийн үйлчилгээтэй холбоотой хэсэгт 85 оролцогч хариулснаас 69 нь уг үйлчилгээний талаар эерэг дүгнэлттэй байна. КОВИД-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлын үеэр халамжийн эрх нээлгэх, сунгуулахтай холбоотой материалыг халамжийн ажилтнууд цахимаар хүлээж авах шинэ туршлага нэвтрүүлж байгааг ихэнх оролцогч сайшаажээ. Цахимаар халамжийн үйлчилгээнд хандах болсноор эцэг эх, асран хамгаалагчид цаг заваа хэмнээд зогсохгүй хүүхдээ орхиж явахгүйгээр төрийн үйлчилгээг авах боломжтой болж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ, ялангуяа хөдөлгөөний хязгаарлалттай том болсон хүүхдээ хуралд оролцуулахаар авч явах шаардлагагүй болсон зэрэг сайн талуудыг оролцогчид онцгойлон дурджээ.

Цахим үйлчилгээтэй холбоотой хот, хөдөөд нийтлэгээр хоёр асуудал илэрч байна. Нэгд, эцэг эх, асран хамгаалагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оролцох ёстой хурлын товыг эртнээс зарлаж, ажлаа зохицуулан цахимаар оролцох боломжийг хангахад анхаарах шаардлагатай байгаа бөгөөд энэ шалтгаанаар 3 хүүхдийн гэр бүлд хүндрэл үүссэн байна. Хоёрт, мэдээллийн технологийн хүртээмжийг анхаарах ёстой бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамжийг сунгуулахдаа цахим шуудангаар материал ирүүлэх шаардлага тавьж байгаа нь гар утасгүй, цахим шуудан хэрэглэх боломжгүй цөөнгүй эцэг эхэд нэмэлт хүндрэл учруулжээ. Цаашид интернэтийн сүлжээгүй, цахим сүлжээ ашиглах боломжгүй болон ашиглаж чадахгүй хүмүүс байгааг анхаарч, биечлэн үйлчлүүлэх боломжийг давхар хадгалах нь зүйтэй юм. Түүнчлэн, өндөржүүлсэн бэлэн байдлын үеэр шинэ санаачилга бий болгож байгаа бөгөөд тухайлбал, Баянзүрх дүүрэгт хариуцсан эмч нь хөгжлийн бэрхшээлтэй хүн, асран хамгаалагчтай зайнаас хамтран ажиллаж, шаардлагатай материалыг бүрдүүлэн, Комиссын хурлаар оруулан халамжийг сунгуулсан тохиолдол байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн халамж, асаргаатай холбоотойгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг 15 оролцогч

шүүмжилжээ. Салбар Комисс хуралдахгүй удах, сар алгасах явдал гардаг бөгөөд үүний улмаас хүүхдийн халамж, асрамжаас хоног хасагдаж тооцогддог байна. Тэтгэмжид шинээр хамрагдах, жилийн сунгалтаа хийлгэх гэсэн 5 өрхөд хүүхдийн оношийг бүсийн оношилгооны төв, хотын эмнэлгээр баталгаажуулах гэнэтийн нэмэлт шаардлага тавигджээ. Сонсголын бэрхшээлтэй 4 хүүхэд, хөгжлийн бэрхшээлийг нь тодорхой нэрлээгүй 3, нийт 7 хүүхдийг “байнгын асаргаа шаардлагагүй” гэсэн үндэслэлээр салбар Комисс асаргааны тэтгэмжээс хассан байна. Энэ тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг хэрхэн, ямар аргачлалаар шийдэж байгаа нь тодорхойгүй, нэг жил нь асаргааны тэтгэмжид хамруулсан хэр нь дараагийн жилд хүүхдийн байдал өөрчлөгдөөгүй байтал асаргаанаас хасах нь эцэг эх, асран хамгаалагчдын бухимдах шалтгаан болж байна.

БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

ТВ хичээл, зайн сургалтын чанар, хүртээмж


ТВ хичээл, хөл хорионы үеэр хүүхдийн сурахуйг хянах, чиглүүлэх багшийн оролцооны талаар үнэлгээ өгсөн 96 оролцогчоос 4 хүүхэд байнгын асаргаа шаардлагатай улмаас сургуульд явдаггүй тул тайлангийн энэ хэсэгт цэцэрлэгийн насны 9 хүүхэд, сургуулийн насны 83 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчийн хариулыг нэгтгэн дүгнэлээ.

ТВ хичээлийн чанар, хүртээмж

Цэцэрлэгийн насны хүүхэдтэй эцэг, эхчүүд ТВ хичээлийн тухайд сэтгэл хангалуун байгаа бол ЕБС-ийн түвшний ТВ хичээлд өгөх эцэг эхийн үнэлгээ жигд бус байна. 16 оролцогч ЕБС-ийн багш зайн технологи ашиглан хүүхэдтэй холбогдон ажиллаж байгаагийн ачаар зайн сургалт “үр дүн сайтай” байна гэж үнэлжээ. 33 оролцогч ТВ хичээлийг “өгөөж муутай” гэж үнэлсэн бөгөөд хичээл маш хурдан өрнөлтэй, нягт агуулгатай, мөн дохионы хэлний хөрвүүлэг чанар муутай байгааг шүүмжилжээ.

Тавдугаар сард зайн сургалтын тухай онцлох эерэг өөрчлөлт нь сургууль, багш нарын идэвх санаачилга

нэмэгдсэн явдал байв. ЕБС-иуд сурагчидтайгаа холбогдон, цахимаар болон хэвлэмэл материал хүргэж, багш нь дасгал даалгавар өгч, гүйцэтгэлийг хянан, эцэг эхтэй холбогдон заавар зөвлөгөө авахыг санал болгож байсныг 42 оролцогч сайшаажээ. Энэ үзүүлэлтийг дээр дурдсан хүүхдийн өдөр тутмын хичээлийн талаар багштай нягт хамтран ажиллаж байгаа 16 оролцогчийн үзүүлэлт дээр нэмбэл судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй 100 орчим хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдын 60 хувь нь 5 дугаар сард багш, сургуулиас дэмжлэг авсан байна.



Хүүхдийн хичээл сургалтын зэрэгцээ 3 багш эцэг эхэд биеэ анхаарч, хүүхдээ амрааж тэнхрүүлэхийг зөвлөсөн нь эерэг сэтгэгдэл төрүүлжээ.

Сургууль, багшаас дэмжлэг, даалгавар аваагүй оролцогчид хүүхдийнхээ сурах дадлыг дэмжих үүднээс хичээлийг нь давтуулахад өөрийн боломжийн хэрээр анхаарч байгаа ажээ. Гурван оролцогч хүүхдээ хичээл даалгавар хийхэд нь тусалж байгаа ч хангалттай дэмжиж чадахгүй байгаадаа санаа зовж байгаагаа онцлоод, ТВ хичээл нь боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдэд тохирохгүй байна гэж дүгнэжээ. ТВ-ээр дамжуулж байгаа хичээл нь 29 дүгээр сургуулийн хөтөлбөрт нийцэхгүй байгаа тул ТВ хичээл үзэж байгаа ч үлдэц муу байна гэж нэг оролцогч тайлбарлажээ. Хүүхдээ сурлагаар хоцрохоос сэргийлэх үүднээс хувийн багш хөлслөх талаар 2 оролцогч бодож байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 11 хүүхэд өвдсөн, харах хүнгүй тул хөдөө явуулсан, ТВ хичээл үзсэн ч амьд харилцаа байхгүй болохоор сонирхохгүй, өөрийн багш нь биш болохоор ойлгохгүй, яваандаа дургүйцээд үзэхгүй байгаа зэрэг шалтгаанаар 5 дугаар сард үзээгүй байна. Нэмэлт дэмжлэг, тохирох хэрэглэгдэхүүн, нийгмийн харилцаа байхгүй нөхцөлд зөвхөн ТВ хичээлээр сургалт явуулахад хүүхэд бүрд өгөөжтэй байж чадахгүй байна гэв.

Нэгдүгээр ангид сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 5 оролцогч маш их сэтгэл зовнилттой байна. Багш нар тогтмол ажилласны дүнд үсгээ үзээд дуусаж байхад, мөн сургуулийн амьдралын хэмнэл, багш, хамт олонтойгоо дасаж эхэлж байтал хөл хорио тогтоосон учир хичээлийн жилийн ихэнх хугацааг гэртээ эцэг, эх нь багшийн өгсөн даалгаврыг хийлгэж өнгөрүүлжээ. Боловсролын тусгай хэрэгцээтэй 6 настай хүүхэд ТВ хичээл үзэхгүй, сонирхохгүй байгаа тул хичээл хийх, суралцах талаар дадал, туршлага бүрдэхгүй, улмаар хөл хорио цуцлагдаж танхимын сургалт эхлэхээр дасан зохицож чадахгүй сургууль завсардахад хүрэх эрсдэл үүсэж байгаад оролцогчид санаа зовж байна.

Тавдугаар сарын судалгаанд оролцогчид зайн сургалттай холбоотой зарим санал дэвшүүлжээ. Үүнд:

- Зөвхөн ТВ-ээр хичээл үзэх нь сургуульд сурч байгаа туршлага, мэдрэмжийг бий болгож чадахгүй тул ангиараа онлайнгаар холбогдож хичээллэх, багш цахимаар ганцаарчилсан сургалт хийх зэрэг ангид явагддаг харилцааг нөхөх арга хэмжээ авах;
- ТВ хичээлийг сонирхохгүй, хурдыг нь гүйцэхгүй, сууж төвлөрөхгүй, анхаарал нь сарниж буй хүүхдээ хэрхэн ажиллуулах, сурах үйл явцыг нь хэрхэн дэмжих, мэдэхгүй байгаа зүйлийг нь заах, давтуулах аргаа олохгүй байгаа эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөх, тэдэнд зориулсан ТВ хичээл явуулах;
- ТВ хичээлийн тухайд багш нь дан лекцээр бус ТВ нэвтрүүлэг шиг туршилт хийх, хүүхдийг оролцуулсан бусад сонирхолтой арга, зочны ярилцлага зэргийг ашиглан идэвхтэй сургахад анхаарахыг хүсжээ.

Ирэх хичээлийн жилийн элсэлт

КОВИД-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон хөл хорионы улмаас 5 дугаар сард явагдах ёстой 2020-2021 оны хичээлийн жилийн элсэлтийн бүртгэлийг 8 сард явуулахаар хойшлуулах шийдвэрийг БСШУС-ын Сайд гаргаад байна. Энэхүү судалгаанд энэ жил сургуульд элсэх хүүхэдтэй 20 оролцогч туршлагаасаа хуваалцжээ.

Нийт 20 оролцогчоос 7 хүн сургуулийн элсэлттэй холбоотой мэдээлэл, сургуулийн танилцуулгыг цахимаар болон багштай нь уулзаж авчээ. 11 оролцогч сургуулийн бүртгэлтэй холбоотой мэдээлэл 8 сар дөхүүлээд ирнэ гэсэн хүлээлттэй, хүүхдээ намар бүртгүүлэхээр бэлдэж байна.

Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй 6 хүүхдийг 9 сараас харьяа цэцэрлэгт нь өгөхөөр бэлдэж байна. 5 настай хүүхэдтэй орон нутгийн нэг оролцогч КОВИД-19-ийн цар тахлын эрсдэл буурахгүй бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуульгүй хоцрох

эрсдэл улам нэмэгдэнэ хэмээн санаа зовж байгаагаа илэрхийлжээ.

Ер нь өмнөх жилүүдийн нөхцөл байдалтай харьцуулахад, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчид хүүхдээ ЕБС-д элсүүлэх хүсэл эрмэлзэл нь нэмэгдэн, идэвхтэй бэлдэж байна. Эцэг эхчүүд олон асуултад хариу хүсэж байгаагийн дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах шинэ эрх зүйн орчинтой холбоотой асуулт олон байв. Тухайлбал, 8 дугаар сард элсэлт эхлэх тохиолдолд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын комисс хуралдаж тусгай, эсвэл энгийн сургуульд элсүүлэх зөвлөмжөө гаргаж амжих эсэх, Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл хуралдаж тохирох хэрэглэгдэхүүний зөвлөмж гаргах, уг зөвлөмжийн дагуу сургууль бэлтгэлээ ханган, багш нь Ганцаарчилсан сургалтын/ дэмжлэгийн хөтөлбөр боловсруулж амжих эсэх зэрэг асуултауд гарч байгаа ч хариулт одоогоор алга байна.


3. ЭЦЭГ ЭХ, ХҮҮХДИЙН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

Судалгаанд оролцсон 96 оролцогч гэр бүлийн гишүүдийнхээ сэтгэл санааны байдлын тухай мэдээлэл өгчээ. Үүнээс 19 оролцогч (19.8%) нь сэтгэл санааны байдал тогтуун байна гэж үнэлээд, хүүхдээ хөдөө явуулсан, эсвэл хөл хорионоос өмнө ч олон жил хүүхдээ асран гэртээ сууж байгаадаа хүлээцтэй ханддаг болсон, тэргэнцэртэй хүүхдээ гадуур зөөж явахаа больсон, туслах хүнтэй зэрэг нэмэлт тайлбар өгчээ. Хөл хорио тогтоосноор гэр бүл, хүүхдүүддээ цаг гаргаад харин ч давуу талтай байна гэж 2 оролцогч хариулснаас харахад байнга завгүй байдаг хүмүүст энэ цаг хугацаа гэр бүлийнхэнтэйгээ хамт

байх боломжийг олгож байна.

Оролцогчдын дийлэнх буюу 70.9 хувь нь сэтгэл санааны хямралтай байгаа бөгөөд энэ нь хүүхэд гадуур гарч чадахгүй байгаа, өөрөө ажилгүй болсон, туслах хүн байхгүй зэрэгтэй холбоотой ажээ. Оролцогчид сэтгэл зүйн асуудал, хямралыг өөрөө мэдээлэл хайх, гэр бүл, найз нөхдөөсөө дэмжлэг авах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бусад эцэг эхтэй ярилцах зэргээр даван туулахыг хичээдэг гэжээ. Мэргэжлийн зөвлөгөө авах нь харьцангуй бага байна.

ТУЛГАМДСАН АСУУДЛАА ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ АРГУУД



Хөдөө орон нутгийн 8 оролцогч сэтгэл санаагаа тайван байлгах, стресс тайлах тухай бодож, санаачилга гаргаж байгаа ч орон нутагт орчин, нөхцөл бүрдээгүй тул хэрэгжүүлж чадаагүй байна, 12 оролцогч ямар арга хэмжээ авахаа мэдэхгүй байна гэж хариулжээ.

82 оролцогч хүүхдийн зан ааш, сэтгэл санааны байдлын талаар хариулжээ. Хөл хорионы үеэр хүүхдүүд сургууль, багш, найз нөхдөө үгүйлж байгааг оролцогчид ажигласан байна. Хүүхдийн зан ааш өөрчлөгдөөгүй гэж хариулсан 22 оролцогчийн дийлэнх нь хүүхэд харах хүнтэй, хөдөө явуулсан, хөгжлийн бэрхшээлийн улмаас олон жил гэртээ байсан зэрэг шалтгаанаар тайлбарлажээ. Хөвсгөл аймагт багш нь хүүхдүүдтэй байнгын харилцаатай байгаа нь хүүхдийн сэтгэл санаа өөдрөг, тайван байхад нөлөөлж байгаа гэж нэг оролцогч дүгнэжээ. Зургаан оролцогч хүүхдийн зан ааш, сэтгэл санааны байдалд өөрчлөлт орсон эсэхийг тодорхой хэлж мэдэхгүй байна гэжээ.

56 хүүхдийн зан ааш, сэтгэл санааны байдалд өөрчлөлт гарч, уур уцаартай болж нойр нь муудан, ганцаардмал зожиг болж байгааг эцэг эх, асран хамгаалагч нь анзаарчээ. 10 оролцогч энэ тохиолдолд ямар нэг арга хэмжээ аваагүй, ямар арга хэмжээ авахаа мэдэхгүй байна гэсэн бол 13 оролцогч найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ зөвлөлдөн тухайн бүрд нь арга хэмжээ авч байгаа ажээ. Хүүхдийг тайвшруулах үүднээс сонирхлыг нь дагуулан утас, компьютероор юм үзүүлэх, амттан авч өгч гэрээс гаргахгүй аргацааж байгаа ч амттан болон дэлгэцэд донтох үр дагаварт хүргэнэ хэмээн эмээж байгаа аж. Нэг оролцогч энэ асуудлаар мэргэжлийн сэтгэл зүйчдэд хандан зөвлөгөө авчээ.

Оролцогчид хөл хорионы үеэр бусад хүүхэдтэй харилцах, идэвхтэй тоглох, гадаа гарах боломж нь хязгаарлагдсан хүүхдийн сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих талаар мэдээлэл, зөвлөгөө авахыг хүсэж байгаа ч сэтгэлзүйн үйлчилгээ хүртээмжгүй байгааг онцолжээ. Сэтгэл гутрал, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд төрөөс анхаарах хэрэгтэй гэж 4 оролцогч үзсэн байна.

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбоо, Монголын Дауны холбоо, Монголын Хараагүйчүүдийн Үндэсний холбоо, Эпилепси бүлэг, Монголын Аутизмын холбоо зэрэг байгууллагын гишүүд оролцов. Тэд Архангай, Баян-Өлгий, Дундговь, Дорнод, Завхан, Орхон,

Ховд, Хөвсгөл, Говь-Алтай, Өвөрхангай, Сүхбаатар аймаг, Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Сүхбаатар, Баянзүрх, Баянгол, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт амьдардаг хараа, сонсгол, оюун ухаан болон хэл ярианы бэрхшээл, тархины саажилт, хөдөлгөөний бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчид юм.

